

XVIII-XX зууны эхэн үеийн Монголын ноёд язгууртны давхраажилтын асуудалд (Дайчин вангийн хошууны жишээн дээр)

Н.Хатанбаатар

Монголын Үндэсний Түүхийн Музей, судлаач

Өгүүллийн товч утга: Зохиогч эл өгүүлэлд, Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгмийн дээд хэсгийг бүрдүүлж агсан ноёд язгууртнуудын дотоод бүрэлдэхүүн, давхраажилтын асуудлыг тухайн үеийн томоохон хошууны архивын баримтад тулгуурлан, орчин үеийн давхраажлын онолын үүднээс авч үзэхийг оролдсон юм.

Түлхүүр үг: засаг ноёд, тайж нар, дээд лам нар, давхраажилт

Монголын түүх судлалд Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгэм, эдийн засгийн түүхийн ерөнхий асуудлуудыг марксист онол, арга зүйн үүднээс тодруулсан тойм судалгаа урьд нь нэлээд хийгдсэн билээ. Өдгөө эл үеийн Монголын нийгмийн бүтцийн түүхийг тухайн үеийн тодорхой аймаг, хошууны жишээн дээр орчин үеийн нийгмийн бүтцийн судалгааны шинэлэг онол, арга зүйд тулгуурлан судлах нь чухал байна. Чингэснээр тухайн хошууны нийгмийн бүтцийг тэр үеийн Монголын нийгмийн бүтцийн ерөнхий ханан дээр буулган харж, нийгмийн тодорхой бүлэг, давхраануудын нийгэмд эзлэх харилцан адилгүй байр суурь, эрх үүрэг, ашиг сонирхол, тэдгээрийн хоорондын харилцааны талаар илүү нарийвчилсан судалгаа явуулах бололцоо бүрдэх юм.

Бид эл өгүүлэлд, Халхын Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны жишээн дээр XVIII-XX зууны эхэн үеийн Монголын нийгмийн бүтцийн дээд хэсгийг бүрдүүлж агсан ноёд язгууртнуудын давхраажилтын төлөвшилт, өөрчлөлтийн зарим асуудлыг тодруулахыг хичээв. Чингэхдээ Манжийн эрхшээлийн үеийн Ар Монголын хошуудаас Дайчин вангийн хошууг сонгон авсан нь Нэгдүгээрт, Эл хошуу Монголын төв хэсэгт оршдог, газар нутаг, хүн ам, мал хөрөнгөөрөө Халхын томоохон хошуудын нэг байсан, Хоёрдугаарт, Тус хошууны түүхэнд холбогдох архивын баримт бичиг, судалгааны эх хэрэглэгдэхүүн нэлээд байгааг харгалзан үзэв.

Дайчин вангийн хошуу нь 1691 оны Долнуурын чуулганаар байгуулагдсан бөгөөд Манжийн хуулиар батлагдсан албан ёсны нэр нь «Халхын умар замын баруун гарын зүүн этгээдийн хошуу» байжээ. Тус хошуу XVIII зууны эхэн үед өөрийн хошуу ноёдын хуучин цолоор Дайчин засгийн хошуу, XIX зууны дунд үеэс Дайчин вангийн хошуу гэгдэж байгаад Олноо өргөгдсөний үеэс Эрдэнэ дайчин вангийн хошуу нэртэй болжээ. Тус хошуу Халхын хамгийн олон хүн амтай том хошуудын нэг байсан бөгөөд түүнийг «Түмэн айлтын хошуу» гэж нэрлэх явдал байжээ. Тухайлбал, 1854 онд тус хошууны бүх хүн ам 16757 байсан бол 1918 онд 19144 болж өсчээ.

Манж Чин улсын эрхшээлд орсон нь Монголын нийгмийн бүтэц, давхраажилтын харилцаанд нэлээд өөрчлөлт оруулсан юм. Манжийн төрөөс Монголын нийгмийн томоохон бүлэг, давхраануудын дунд зэрэг дэвийн нарийн шаталсан тогтолцоог бий болгосноор нийгмийн ялгаралыг улам идэвхжүүлсэн байна. XVIII-XX зууны эхэн үед Дайчин вангийн хошууны хүн ам нь Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийт хүн амын адилаар нийгмийн олон бүлэг, давхраанаас бүрдэж байжээ. Тэдгээрээс бид энэ удаа тус хошууны нийгмийн бүтцийн дээд язгуурлаг давхрааг бүрдүүлж байсан засаг ноёд, тайж нар, дээд лам нар гэсэн нийгмийн бүлгүүд хэрхэн бүрэлдэж төлөвшсөн хийгээд өөрчлөгдөн хувьсаж ирсэн түүхийн зарим онцлог асуудлыг тодруулах юм.

Засаг ноёд. Дайчин вангийн хошууны засаг ноёд нь Батмөнх даян хааны отгон хөвгүүн Гэрсэнз жалайр хунтайжийн ач хөвгүүн Абтай ханы удам Чин

зэрэг тайжид 15 гэх зэргээр хамжлага өрх олгохоор заажээ. Чингэж Манжийн хуулиар засаг ноёд, тайж нарын хамжлагын тоог хатуу тогтоож өгсөн тул өөрсдийн хамжлагын тоог дээш мэдүүлэхдээ хуулиар тогтоосон хэмжээнд тааруулж, нуун дарагдуулах явдал гарч байв. Тухайлбал, 1831 онд засаг Цэдэндорж манж сайдын газарт өөрийн хамжлагын тоог 60 хэмээн мэдүүлсэн боловч түүнээс 5 жилийн дараа 1836 онд тус хошууны хүн, малыг байцаан тоолоход дээрх Цэдэндоржийн хамжлагын өрхийн тоо 1661 буюу нийт хүн амын 25 хувийг эзэлж байжээ.

Хошууны засаг ноёд бол Манжийн хааны орон нутаг дахь гол төлөөлөгчийн шинжтэй байж, Манжийн хаанд шинэ жилийн амгалан айлтгах, шинэлэхийн жасаанд биеэр очих, гурваас дөрвөн жилд хааны ордонд бараалхах, Мураны авд оролцох зэрэг үүрэгтэй байв. Дайчин вангийн хошууны засаг ноёд нь «Халхын умар замын баруун гарын зүүн этгээдийн хошууг захирагч» хэмээх мөнгөн тамга хэрэглэн хэрэг шийтгэж байжээ. Засаг ноён нь Манжийн хааны зарлигаар угсаа залгамжлан тамгын газрын тусламжтайгаар хошууныхаа аливаа хэргийг эрхлэн шийтгэж байв.

Тэрчлэн тус хошууны засаг ноёд бусад томоохон засаг ноёдын адил өөр өөрсдийн хошууны хэргийг эрхлэхийн зэрэгцээ Манжийн засаг захиргааны албан тушаалууд болох чуулганы дарга, чуулганы дэд дарга, аймгийн туслагч жанжин, түүний зөвлөгч тушаал, Улиастай, Их Хүрээний амбан сайдуудын дэргэд жасаалах зэрэгт томилогдон ажилладаг нөлөө бүхий ноёд байв. Тус хошууны ноёдоос Түшээт хан аймгийн чуулган даргын тушаалд 4 ноён (Чавагаримпил, Цэдэндорж, Эрэгзэндорж, Цэрэндорж), дэд чуулган даргын тушаалд мөн 4 ноён (Чавагаримпил, Чавагдорж, Цэдэндорж, Цэрэндорж), аймгийн туслагч жанжны тушаалд 5 ноён (Цэнгүнжав, Чавагдорж, Цэдэндорж, Эрэгзэндорж, Ханддорж), аймгийн хэбэй (зөвлөх Н.Х) жанжны тушаалд 3 ноён (Цэнгүнжав, Цэдэндорж, Ханддорж) тус тус томилогдон ажиллаж байв. Түүнчлэн нутаг орондоо Амбан ван хэмээн алдаршсан хошой чин ван Цэрэндорж Ховдын туслан хэрэг шийтгэгч сайд, Улиастайн хуубийн сайдын тушаалд томилогдож байжээ. Дээрхээс үзвэл, тус хошууны засаг ноёд нь нийгмийн статус, төрийн удирдлага, засаглалд оролцох нөлөөлөл, байр суурийн хувьд тухайн үеийн монгол ноёдын дээд шатанд багтаж байсан нь мэдэгдэж байна.

Дайчин вангийн хошууны засаг ноёд нь нийгмийн статусын хувьд төдийгүй эдийн засгийн байдлаараа тухайн үеийн Халхын засаг ноёдын дунд чинээлэгт тооцогдож байв. Тус хошууны засаг ноёд тэр үеийн үндсэн баялаг болж байсан хошууны нийт малын багагүй хэсгийг эзэмшиж байв. Энэ тухай зарим баримт дурдвал, 1836 онд хошой чин ван Цэдэндорж адуу 1919, тэмээ 132, үхэр 1042, хонь 5156, нийт 8249 малтай байжээ. Мөн ван Цэдэндоржийн зөвхөн адуу нь 1851 онд 3594, 1858 онд 2578 болсон байжээ. Харин 1918 оны тоо бүртгэлээр Эрдэнэ дайчин ван Жамбалдорж адуу 1024, тэмээ 8, үхэр 543, хонь ямаа 240, нийт 3410 малтай байсан аж. Түүнчлэн засаг ноёд хошууны нутгийн аль шилдэг сайныг сонгон эзэмшиж, мал сүргээ адуулгадаг байжээ. Тийнхүү тус хошууны засаг ноёд хошууныхаа газар нутгийг хувиарлах эрхийг эдэлж, үйлдвэрлэлийг гол зохион байгуулагч болж, нийгмийн бүтцийн дээд оройд байсаар иржээ.

Тайж нар. Тайж нар бол Монголын хаад, язгууртны үржвэр салаа бөгөөд монгол язгууртны доторх хамгийн олон тоотой бүлэг нь юм. XVIII-XX зууны эхэн үед Монголын нийт тайж нь 4 зэрэгт хуваагдаж байв. Манжийн хууль ёсоор Монголын хан, чин вангийн хөвгүүнийг тэргүүн зэрэг тайж; жүн ван, бэйлийн хөвгүүдийг дэд зэрэг тайж; бэйс, гүнгийн хөвгүүдийг гутгаар зэрэг тайж болгоод, дээрх гурван зэрэг тайж нарын хөвгүүдийг дөтгөөр зэрэг тайж хэмээдэг байв.

Үүнээс гадна Халхын тайж нар нь дотроо удам гарлаасаа хамаарч ойр төрлийн болон харьяат тайж гэсэн ялгавартай байв. Үүнийг Манжийн хуульд «Түшээт хан, Сэцэн хан аймгийн 43 хошууны тайж нарын дотор Чингис хааны хөвгүүд, ач нараас үржсэнийг төрлийн тайж болго. Чингис хааны дүү Бөх Бэлгэтэй нарын хөвгүүд, ач нараас үржсэнийг нь харьяат тайж болго» хэмээн өгүүлжээ. Эндээс үзвэл, төрлийн тайж нар нь Чингис хааны үр хөвгүүдийн удам бол харьяат тайж нар нь Чингисийн дүү Бөх Бэлгэтэй нарын удамчир, залгамчир болох ажээ.

Монголын эрдэмтэн С.Бадамхатан Халхын Сэцэн хан аймгийн Боржигин сэцэн вангийн хошууг, Японы эрдэмтэн О.Хироки мөн Сэцэн хан аймгийн Бишрэлт засгийн хошууны нийгмийн нэгжүүдийг нарийвчлан судлаад, Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгэмд уламжлалт отог буюу баг хэмээх нийгмийн зохион байгуулалт байсаар ирсэнийг нотолсон байна. Тэрхүү хошууны сум, шавийн алинд ч хамаарагдахгүй отог, багийн тогтолцоо XVIII-XIX зууны үед Дайчин вангийн хошуунд ч байсан нь архивын баримтаас мэдэгдэж байна. Дайчин вангийн хошууны боржигин тайж нар нь дотроо төрөл болон харьяат тайж хэмээн хуваагдаж, суманд захирагдахгүй, тусгай хэдэн баг болж, тусдаа захиргаатай байсан ажээ.

Дайчин вангийн хошуунд XIX зууны 20-иод оны эхэн үед тайж нарын 19 баг байжээ. Тэдгээр багууд нь Абтай ханы удам Чин хунтайж Дэбсэрэлийн үр хойчисоос салбарласан төрлийн тайж нарын 9 баг, мөн Чингисийн дүү нарын удмаас үржин гарсан харьяат тайж нарын 10 багаас бүрдэж байжээ. Тэдний дотор «гүнгийн зэрэг тэргүүн зэрэг тайж 1, тэргүүн зэрэг тайж 4, дэд зэрэг тайж 2, дөтгөөр зэрэг тайж 52, зэрэг олоогүй тайж 36, тайж лам 50¹» нийт 145 тайж байжээ. Тус хошууны тайж нарын удам угсааны доторхи салбар салаа болж байсан тэдгээр баг тус бүр нь өөрсдийн дотроос томилогдсон төрлийн даргадаа захирагддаг байсан аж. Төрлийн дарга нь хошууны тамгын газар шууд захирагдаж, тайж нарын удам угсаа, ёс суртахууны асуудлыг хариуцдаг байжээ.

1831 онд засаг хошой чин ван Цэдэндоржийн үед тус хошуунд гүнгийн зэрэг тэргүүн зэрэг тайж 1, сул тэргүүн зэрэг тайж 5, дэд зэрэг тайж 2, хошууны хэргийг туслагч дөтгөөр зэрэг тайж 1, сул дөтгөөр зэрэг тайж 47, нийтдээ 55 тайж байсан нь архивын дансанд тэмдэглэгджээ¹. Дээрх бүртгэлд зөвхөн насанд хүрч зэрэг олсон тайж нарыг хамруулсан байна. Тэр үед тус хошууны тэргүүн зэрэг тайж нар нь засаг Цэдэндоржийн ойр төрлийн ах, дүү, эсвэл хөвгүүд нь байсан бөгөөд тэд тус бүр 15 хамжлагатай байв. Харин дэд зэрэг тайж нар нь 12, дөтгөөр зэрэг тайж нар нь 4 хамжлага эзэмшиж байсан бөгөөд таван тайж өөрийн гэх хамжлагагүй байсан аж. Үүнээс 5 жилийн дараа 1836 оны тооллогоор нийт тус хошууны тайж нарын тоо 86 болсон байжээ.

Өмнө өгүүлсэн төрлийн тайж нараас гадна XVIII-XX зууны эхэн үеийн Дайчин вангийн хошууны данс бичиг, хараанд авга, онниуд тайж нар гэх буюу заримдаа авга ястай, онниуд ястай тайж нар хэмээн бичсэн нь цөөнгүй тааралдаж байна. Дээр өгүүлсэн ван Цэдэндоржийн үеийн дансанд «авга ястай харьяат дөтгөөр зэрэг тайж 19, онниуд ястай харьяат дөтгөөр зэрэг тайж нар 25, убаши хэмээх төрлийн тайж Чавагжавын нуун дарсан онниуд тайж нар 49» тус тус бүртгэгджээ. Харин 1907 оны баримтаас үзэхэд, тус хошууны авга ястай харьяат тайж 33, онниуд ястай харьяат дөтгөөр зэрэг тайж 24 байсан нь архивын дансанд тэмдэглэгджээ.

Бид урьд нь авга, онниуд тайж нарын угсаа гарлын талаар судалгаа явуулж, тэдгээр тайж нар бол XVI-XVII зууны үед өвөрлөгч аймгуудаас Халхад орж ирсэн Чингисийн дүү Бөх Бэлгэдэй, Хачиун нарын угсааны харьяат тайж нар мөн болохыг тодруулсан билээ. Тус хошууны харьяат тайж нарын гэрийн

үеийн бичмэлээс үзвэл, Дайчин вангийн хошууны авга тайж нар нь Бөх Бэлгэдэйн XVIII үеийн ач Ном тэмгэтийн угсааны тайж нарын үр хойчис, харин онниуд тайж нар нь Хачиун ноёны XX үеийн ач Баяндай хонгор ноёны удмын тайж нар байжээ. Тэдгээр авга, онниуд харъяат тайж нар нь XVIII-XX зууны эхэн үед Дайчин вангийн хошууны тайж нарын доторх тусгай отог болж байсан аж. Хэдийгээр тэдгээр тайж нар угсаа гарлын хувьд язгуурлаг боловч нийгмийн байр суурийн хувьд төрлийн тайж нарыг бодвол харьцангуй доогуур түвшинд байсаар иржээ.

Тийнхүү Манж Чин улсын үед нийгмийн дээд давхрааныхны дотор эрх мэдэл, эд хөрөнгөний ялгаа тогтоож, ялгавартай хандах болсон нь нийгмийн ялгаралыг идэвхжүүлж, урьд цөөн байсан тайж нарын тоо эрс олширчээ. 1854 онд Дайчин вангийн хошууны нийт тайж нарын тоо 80 буюу тухайн үеийн нийт хүн амын 0,5 хувийг бүрдүүлж байсан бол 1858 онд тайж нарын өрх 158, ам 829 болжээ. 1918 оны тоо бүртгэлээр, тус хошуунд 18-аас доош насны тайж 90, 18-аас дээш насны тайж 71, нийт 161 тайж байжээ. Энэ нь тус хошууны нийт хүн амын 1 орчим хувийг бүрдүүлж байв.

Тайж нар Манжийн эрхшээлийн эхэн үед алба татвар төлдөггүй, хуулиар тогтоосон цөөн тооны хамжлага нараасаа алба авдаг байв. XIX зууны эхэн үеэс тайж нар элдэв албанд өртөгдөх болжээ. Тайж нарын дунд зэрэг дэсийн төдийгүй хөрөнгө чинээний ялгаа улам ихсэх болж, ядуурсан тайж нарыг албаны ядуу тайж, хохь тайж гэж нэрлэх болжээ. 1837 онд Дайчин вангийн хошууны огт гар хоосон ядуу тайж 27 бүртгэгдсэн нь тухайн үеийн тайж нарын нэлээд хэсэг нь ядуурч, хохь тайжийн байдалд ороод байсныг харуулж байна.

Дээд лам нар. Лам нар бол чухамдаа монголчууд Манжийн эрхшээлд байх үед жинхэнэ ёсоор бие даан төлөвшсөн нийгмийн шинэ давхраа гэж үзэж болох юм.

XVIII-XIX зууны үед Монголын лам нарын давхраа нь дотроо нийгэмд эзлэх байр суурь, зэрэг дэв, хөрөнгө чинээгээрээ харилцан ялгавар бүхий нийгмийн бичил бүлгүүдэд хуваагдаж байв. Бид Дайчин вангийн хошууны нийт лам нарыг мяндаг тушаалтан лам нар ба энгийн лам нар гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваан авч үзэж байна. Мяндагтан лам нарын нэлээд нь язгууртан гаралтай бөгөөд тус хошууны хүрээ хийдийн эрхийг баригчид юм. Тиймээс тэднийг тухайн үеийн нийгмийн язгуурлаг давхраанд багтаан үзэж байгаа болно. Харин мяндаг тушаалгүй энгийн лам нар нь их төлөв жирийн малчдаас гаралтай, хүрээ хийдийн хөрөнгө баялагийг эзэмшин зарцуулах эрхгүй байв.

Орон нутгийн хүрээ хийдийн лам нарыг хурлын тушаалтан гэдэг лам нар голлон захирч байв. Үүнээс хамба бол хүрээ хийдийн хамгийн гол тушаалтан, цорж бол хамбыг орлож, хүрээ хийдийн бүх ажлыг хянан явуулдаг байв. Дайчин вангийн хошууны ноёд нь хошууны нутагт томоохон сүм хийдийг байгуулж байсан нь тус хошуунд лам нарын тоо олшроход нөлөөлжээ. Тус хошууны гол хийд бөгөөд төв нь Вангийн хүрээ байв. Уг хүрээг 1666-1667 онд Түшээт хан Чахундоржийн дүү Баатар бэйл өөрийн гэрийг цогчин сүм болгон Лигшиддонголин хийд нэртэйгээр анх үүсгэсэн ажээ. Улмаар 1686 онд засаг Чамчугнамжилын үед тус хошууны нутгийн өмнө этгээд Ачуут хэмээх газар суурьшсанаас хойш Вангийн хүрээ гэж нэрлэгдсэн байна. XX зууны эхний байдлаар Вангийн хүрээ нь 27 дацан, 30 орчим дуган, жас, 2000 орчим лам хуврагтай байжээ.

Вангийн хүрээнд тус хошууны лам нарын олонх нь сууж, хурал номын үйл ажиллагаа явуулсаар иржээ. 1823 оны байдлаар тус хошуунд нийт 1221 лам нар байсан мэдээ бий. Тэдгээр лам нарыг тэргүүлэн захирсан ламыг да лам, түүний туслахыг дэмч лам хэмээн нэрлэдэг байжээ. 1831 онд засаг Цэдэндоржийн үед тус хошууны хүрээ хийдийн лам нарын дотор «да лам гэлэн

Үүнээс гадна Халхын тайж нар нь дотроо удам гарлаасаа хамаарч ойр төрлийн болон харьяат тайж гэсэн ялгавартай байв. Үүнийг Манжийн хуульд «Түшээт хан, Сэцэн хан аймгийн 43 хошууны тайж нарын дотор Чингис хааны хөвгүүд, ач нараас үржсэнийг төрлийн тайж болго. Чингис хааны дүү Бөх Бэлгэтэй нарын хөвгүүд, ач нараас үржсэнийг нь харьяат тайж болго» хэмээн өгүүлжээ. Эндээс үзвэл, төрлийн тайж нар нь Чингис хааны үр хөвгүүдийн удам бол харьяат тайж нар нь Чингисийн дүү Бөх Бэлгэтэй нарын удамчир, залгамчир болох ажээ.

Монголын эрдэмтэн С.Бадамхатан Халхын Сэцэн хан аймгийн Боржигин сэцэн вангийн хошууг, Японы эрдэмтэн О.Хироки мөн Сэцэн хан аймгийн Бишрэлт засгийн хошууны нийгмийн нэгжүүдийг нарийвчлан судлаад, Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгэмд уламжлалт отог буюу баг хэмээх нийгмийн зохион байгуулалт байсаар ирсэнийг нотолсон байна. Тэрхүү хошууны сум, шавийн алинд ч хамаарагдахгүй отог, багийн тогтолцоо XVIII-XIX зууны үед Дайчин вангийн хошуунд ч байсан нь архивын баримтаас мэдэгдэж байна. Дайчин вангийн хошууны боржигин тайж нар нь дотроо төрөл болон харьяат тайж хэмээн хуваагдаж, суманд захирагдахгүй, тусгай хэдэн баг болж, тусдаа захирагатай байсан ажээ.

Дайчин вангийн хошуунд XIX зууны 20-иод оны эхэн үед тайж нарын 19 баг байжээ. Тэдгээр багууд нь Абтай ханы удам Чин хунтайж Дэбсэрэлийн үр хойчисоос салбарласан төрлийн тайж нарын 9 баг, мөн Чингисийн дүү нарын удмаас үржин гарсан харьяат тайж нарын 10 багаас бүрдэж байжээ. Тэдний дотор «гүнгийн зэрэг тэргүүн зэрэг тайж 1, тэргүүн зэрэг тайж 4, дэд зэрэг тайж 2, дөтгөөр зэрэг тайж 52, зэрэг олоогүй тайж 36, тайж лам 50» нийт 145 тайж байжээ. Тус хошууны тайж нарын удам угсааны доторхи салбар салаа болж байсан тэдгээр баг тус бүр нь өөрсдийн дотроос томилогдсон төрлийн даргадаа захирагддаг байсан аж. Төрлийн дарга нь хошууны тамгын газар шууд захирагдаж, тайж нарын удам угсаа, ёс суртахууны асуудлыг хариуцдаг байжээ.

1831 онд засаг хошой чин ван Цэдэндоржийн үед тус хошуунд гүнгийн зэрэг тэргүүн зэрэг тайж 1, сул тэргүүн зэрэг тайж 5, дэд зэрэг тайж 2, хошууны хэргийг туслагч дөтгөөр зэрэг тайж 1, сул дөтгөөр зэрэг тайж 47, нийтдээ 55 тайж байсан нь архивын дансанд тэмдэглэгджээ". Дээрх бүртгэлд зөвхөн насанд хүрч зэрэг олсон тайж нарыг хамруулсан байна. Тэр үед тус хошууны тэргүүн зэрэг тайж нар нь засаг Цэдэндоржийн ойр төрлийн ах, дүү, эсвэл хөвгүүд нь байсан бөгөөд тэд тус бүр 15 хамжлагатай байв. Харин дэд зэрэг тайж нар нь 12, дөтгөөр зэрэг тайж нар нь 4 хамжлага эзэмшиж байсан бөгөөд таван тайж өөрийн гэх хамжлагагүй байсан аж. Үүнээс 5 жилийн дараа 1836 оны тооллогоор нийт тус хошууны тайж нарын тоо 86 болсон байжээ.

Өмнө өгүүлсэн төрлийн тайж нараас гадна XVIII-XX зууны эхэн үеийн Дайчин вангийн хошууны данс бичиг, хараанд авга, онниуд тайж нар гэх буюу заримдаа авга ястай, онниуд ястай тайж нар хэмээн бичсэн нь цөөнгүй тааралдаж байна. Дээр өгүүлсэн ван Цэдэндоржийн үеийн дансанд «авга ястай харьяат дөтгөөр зэрэг тайж 19, онниуд ястай харьяат дөтгөөр зэрэг тайж нар 25, убаши хэмээх төрлийн тайж Чавагжавын нуун дарсан онниуд тайж нар 49» тус тус бүртгэгджээ. Харин 1907 оны баримтаас үзэхэд, тус хошууны авга ястай харьяат тайж 33, онниуд ястай харьяат дөтгөөр зэрэг тайж 24 байсан нь архивын дансанд тэмдэглэгджээ.

Бид урьд нь авга, онниуд тайж нарын угсаа гарлын талаар судалгаа явуулж, тэдгээр тайж нар бол XVI-XVII зууны үед өвөрлөгч аймгуудаас Халхад орж ирсэн Чингисийн дүү Бөх Бэлгэдэй, Хачиун нарын угсааны харьяат тайж нар мөн болохыг тодруулсан билээ. Тус хошууны харьяат тайж нарын гэрийн

үеийн бичмэлээс үзвэл, Дайчин вангийн хошууны авга тайж нар нь Бөх Бэлгэдэйн XVIII үеийн ач Ном тэмгэтийн угсааны тайж нарын үр хойчис, харин онниуд тайж нар нь Хачиун ноёны XX үеийн ач Баяндай хонгор ноёны удмын тайж нар байжээ. Тэдгээр авга, онниуд харъяат тайж нар нь XVIII-XX зууны эхэн үед Дайчин вангийн хошууны тайж нарын доторх тусгай отог болж байсан аж. Хэдийгээр тэдгээр тайж нар угсаа гарлын хувьд язгуурлаг боловч нийгмийн байр суурийн хувьд төрлийн тайж нарыг бодвол харьцангуй доогуур түвшинд байсаар иржээ.

Тийнхүү Манж Чин улсын үед нийгмийн дээд давхрааныхны дотор эрх мэдэл, эд хөрөнгөний ялгаа тогтоож, ялгавартай хандах болсон нь нийгмийн ялгаралыг идэвхжүүлж, урьд цөөн байсан тайж нарын тоо эрс олширчээ. 1854 онд Дайчин вангийн хошууны нийт тайж нарын тоо 80 буюу тухайн үеийн нийт хүн амын 0,5 хувийг бүрдүүлж байсан бол 1858 онд тайж нарын өрх 158, ам 829 болжээ. 1918 оны тоо бүртгэлээр, тус хошуунд 18-аас доош насны тайж 90, 18-аас дээш насны тайж 71, нийт 161 тайж байжээ. Энэ нь тус хошууны нийт хүн амын 1 орчим хувийг бүрдүүлж байв.

Тайж нар Манжийн эрхшээлийн эхэн үед алба татвар төлдөггүй, хуулиар тогтоосон цөөн тооны хамжлага нараасаа алба авдаг байв. XIX зууны эхэн үеэс тайж нар элдэв албанд өртөгдөх болжээ. Тайж нарын дунд зэрэг дэсийн төдийгүй хөрөнгө чинээний ялгаа улам ихсэх болж, ядуурсан тайж нарыг албаны ядуу тайж, хохь тайж гэж нэрлэх болжээ. 1837 онд Дайчин вангийн хошууны огт гар хоосон ядуу тайж 27 бүртгэгдсэн нь тухайн үеийн тайж нарын нэлээд хэсэг нь ядуурч, хохь тайжийн байдалд ороод байсныг харуулж байна.

Дээд лам нар. Лам нар бол чухамдаа монголчууд Манжийн эрхшээлд байх үед жинхэнэ ёсоор бие даан төлөвшсөн нийгмийн шинэ давхраа гэж үзэж болох юм.

XVIII-XIX зууны үед Монголын лам нарын давхраа нь дотроо нийгэмд эзлэх байр суурь, зэрэг дэв, хөрөнгө чинээгээрээ харилцан ялгавар бүхий нийгмийн бичил бүлгүүдэд хуваагдаж байв. Бид Дайчин вангийн хошууны нийт лам нарыг мяндаг тушаалтан лам нар ба энгийн лам нар гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваан авч үзэж байна. Мяндагтан лам нарын нэлээд нь язгууртан гаралтай бөгөөд тус хошууны хүрээ хийдийн эрхийг баригчид юм. Тиймээс тэднийг тухайн үеийн нийгмийн язгуурлаг давхраанд багтаан үзэж байгаа болно. Харин мяндаг тушаалгүй энгийн лам нар нь их төлөв жирийн малчдаас гаралтай, хүрээ хийдийн хөрөнгө баялагийг эзэмшин зарцуулах эрхгүй байв.

Орон нутгийн хүрээ хийдийн лам нарыг хурлын тушаалтан гэдэг лам нар голлон захирч байв. Үүнээс хамба бол хүрээ хийдийн хамгийн гол тушаалтан, цорж бол хамбыг орлож, хүрээ хийдийн бүх ажлыг хянан явуулдаг байв. Дайчин вангийн хошууны ноёд нь хошууны нутагт томоохон сүм хийдийг байгуулж байсан нь тус хошуунд лам нарын тоо олшроход нөлөөлжээ. Тус хошууны гол хийд бөгөөд төв нь Вангийн хүрээ байв. Уг хүрээг 1666-1667 онд Түшээт хан Чахундоржийн дүү Баатар бэйл өөрийн гэрийг цогчин сүм болгон Лигшиддонголин хийд нэртэйгээр анх үүсгэсэн ажээ. Улмаар 1686 онд засаг Чамчугнамжилын үед тус хошууны нутгийн өмнө этгээд Ачуут хэмээх газар суурьшсанаас хойш Вангийн хүрээ гэж нэрлэгдсэн байна. XX зууны эхний байдлаар Вангийн хүрээ нь 27 дацан, 30 орчим дуган, жас, 2000 орчим лам хуврагтай байжээ.

Вангийн хүрээнд тус хошууны лам нарын олонх нь сууж, хурал номын үйл ажиллагаа явуулсаар иржээ. 1823 оны байдлаар тус хошуунд нийт 1221 лам нар байсан мэдээ бий. Тэдгээр лам нарыг тэргүүлэн захирсан ламыг да лам, түүний туслахыг дэмч лам хэмээн нэрлэдэг байжээ. 1831 онд засаг Цэдэндоржийн үед тус хошууны хүрээ хийдийн лам нарын дотор «да лам гэлэн

Лувсанчойсүрэн, дэд лам гэлэн Наваанбалдан, дэмч лам гэлэн Наваанцэдэн гэх зэргээр гэлэн 22, гэцэл 15» байсан аж. Харин XIX зууны сүүлээр засаг Цэрэндоржийн хошууны хурлын лам нарын нэр, нас, тоо зэргийг мэдүүлж өргөсөн цэсэнд «хурлын лам рабжамба гэлэн Лувсаншарав, да лам гэлэн Наваанлуvsан, дэмч гэлэн Лувсаншарав, гэвхүй гэлэн Лувсанлэгдэв, шавь гэлэн Ишгэлэг, тайж лам Жамсранжав, Цэрэндаш, Усанбалин» гэх зэргээр гэлэн 33, гэцэл 8, тайж лам 3» байжээ. Энэ нь хүрээ хийдэд байнга шавилан суудаг зөвхөн томоохон лам нарыг голлон оруулж тооцсон мэдээ юм.

Дээр өгүүлсэн мяндаг тушаалт лам нар нь сүсэгтэн олны өргөл барьц болон бусад орлоготой ажил эрхэлдэгийн хувьд ихээхэн хөрөнгөлөг бөгөөд нийгэм-эдийн засгийн байр суурийн хувьд ноёд, тайж нараас дутахгүй байжээ. Мөн тэдгээр лам нарын дотор их төлөв хошууны засаг ноён, тайж нарын хөвгүүд буюу ойр төрлийн хүмүүс байх нь түгээмэл байжээ. XIX зууны эхэн үед ван Цэдэндорж өөрийн төрсөн хөвгүүн тэргүүн зэрэг тайж Лувсаннамжилыг тойн лам болгосны дараа өөрийн хамжлагаас 9 хүнийг шилжүүлэн өгч байсан аж. Тийнхүү тайж нарын лам болох явдал цаашид нэмэгдсээр байсан нь 1822 оны Дайчин вангийн хошууны хүн амын бүртгэлд дурдсанаар, тайж лам нарын тоо 50-д хүрээд байснаас мэдэж болно. Энэ нь ноёд язгууртны давхрааны гол цөмийг бүрдүүлж байсан тайж нар болон дээд лам нарын хооронд нийгмийн хэвтээ шугамын мобиль хөдөлгөөн нэлээд хүчтэй явагдах болсоныг харуулах баримт юм.

XVIII-XX зууны эхэн үед Монгол оронд сэхээтний бүлгийг лам нар голлон бүрдүүлж байсан гэх бүрэн үндэстэй юм. Ер нь лам нарын ихэнх нь бүтээллэг үйл ажиллагаа явуулдаггүй, өвөрмөц онцлогтой бүлэг болно. Дурдан буй үед зарим лам нар нь язгуур угсаагүй боловч өөрсдийн авъяас билэг, эрдэм ухаанаараа шалгаран товойж, шашны гүн ухаан, зурхай, эмнэлэг зэрэгт мэргэшин гавж, аграмбын зэрэг хүртэж, дээд лам нарын эгнээнд дэвших явдал гарч байжээ. Энэ нь өрнөдийн нийгмийн бүтцэд түгээмэл ажиглагддаг нийгмийн босоо шугамын шилжилт хөдөлгөөн өгүүлэн буй үеийн Монголын уламжлалт нийгэмд ч байсныг харуулж байгаа юм. Тухайлбал, Дайчин вангийн хошууны харц ардын гэрт мэндэлсэн Дандар аграмба буддын гүн ухаанд нэвтэрч, гавжийн дамжаа барьж, Далай лам хүртэл түүний ухааны цар, номын шидийг бишрэн шавь орж, олонд шагшигдаж байсан нь түүхэнд үлджээ.

Өмнө өгүүлснээс үзвэл, XVIII-XX зууны эхэн үед Монголын нийгмийн бүтцийн дээд оргилыг бүрдүүлж байсан ноёд язгууртнуудын дунд нийгмийн ялгарал, давхраажилтын үйл явц хүчтэй явагдаж байсан нь мэдэгдэж байна. Тодорхой хэлбэл, тухайн үеийн Монголын нийгмийн дээд хэсгийг гагцхүү феодалууд хэмээх нийгмийн том анги бус, харин язгуур угсаа, нийгмийн статус, эрхлэх ажил үүрэг, эрх ямба, хөрөнгө чинээний байдлаараа хоорондоо харилцан ялгавар бүхий нийгмийн бүлгүүд бүрдүүлж байсан гэж үзвэл бодит байдалд илүү нийцтэй болох мэт санагдана.

Резюме: К некоторым вопросам аристократской стратификации Северной Монголии в XVIII-начале XX вв.(на примере хошуна Дайчин вана) В настоящей статье затронуты вопросы о аристократской стратификации Северной Монголии Цинского периода, путем изучения социальной структуры и стратификации аристократов хошуна Дайчин вана, одного из крупного хошуна Центральной Монголии.

В заключении автор рассматривает в описываемый период Монгольская аристократская прослойка состояла из некоторых самостоятельных социальных группов, как князья, тайджи и высшие ламы. И несомненно, что они отличались между собой по некоторым параметрам, включая родовую принадлежность, собственность, права и привилегии, социальное положение и так далее.

Ном зүй

1. А.П.Болобан. Монголия в ее современном торгово-экономическом отношении. Пгр., 1914. стр. 51-52
2. МУУТА. А-16, Д-1, ХН-24, 25
3. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир. УБ., 1997. т.11
4. ГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичиг. Улаанхад. 1989. Дэд дэвтэр. т. 75
5. Мөн тэнд. Т.82
6. МУУТА. М-14, Д-1. ХН-20, 24,25
7. Чин улсын бүгд хууль зүйлийн бичиг. 140-р дэвтэр. УТНС. Гар бичмэлийн сан.
8. МУУТА. Д-1, ХН-19, 20, 24
9. С.Бадамхатан. Боржгин халх- "Этнографийн судлал". Том-IV, Fast-7. УБ., 1970 тал 9-10
- Ока Хироки. Манжийн үеийн Монголын нийгэм дэхь отог, баг- "Монголын түүх, угсаатны судлалын зарим асуудал". Сендай. 2004. тал 65-72
10. МУТА. М-9. Д-1, ХН-1423
11. МУУТА. М-14. Д-1. ХН-20
12. МУУТА. М-14. Д-1. ХН-23
13. МУУТА. М-14. ХН-19, М-9. Д-1. ХН-3399
14. Н.Хатанбаатар. Халхын авга, онниуд, хорчин тайж нарын угсаа гарлын тухай "Түүхийн судлал". Том- XXXIII. Fasc-15.УБ., 2004. тал 64-72
15. МУУТА. М-14. Д-1, ХН-24, ХН-25
- И.М.Майский. Монголия накануне революции. М., 1959. стр. 135
16. МУУТА. М-9. Д-1. ХН-1880
17. И.М.Майский. Монголия накануне революции. М., 1959. стр 122
18. МУУТА. М-14. Д-1, ХН-19
19. МУУТА. М-14. Д-1, ХН-23
20. МУУТА. М-14. Д-1, ХН-1
21. Ж.Болдбаатар. Далай ламын монгол багш. УБ., 1996. т.20